



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ТАНИЛЦУУЛГА

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2015/12



АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 2015 ОНЫ ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэт хот

2015 он

1.Макро эдийн засаг



Төсөв санхүү

Аймгийн төсөвт 73.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 93.9 хувьтай байна. Нийт орлогын 45.3 хувь нь татварын бус орлого бөгөөд өмнөх оноос 74.2 дахин нэмэгдсэн байна. Энэ нь тусгай шилжүүлгийн орлогыг нийт орлогын дүнд оруулдаг болсонтой холбоотой.

Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 87.9 хувийг буюу 73.5 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 3.4 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 16.5 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 16.8 хувийг бараа үйлчилгээний зардалд, 31.5 хувийг хөрөнгийн зардалд, 31.7 хувийг цалин хөлсөнд зарцуулжээ.

Салбарын хувьд эдийн засгийн бусад салбарт 0.6 хувийг, эрүүл мэндийн салбарт 2.4 хувийг, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн салбарт 12.5 хувийг, нийтийн ерөнхий үйлчилгээнд 20.7 хувийг, ангилагдаагүй бусад зардалд 31.5 хувийг, боловсрол соёл урлагийн салбарт 32.3 хувийг зарцуулсан байна.

Өмнөх оноос нийт зарлага санхүүжилт 0.4 хувиар бага, төсвийн орлого 77.4 хувиар нэмэгдсэн байна.



Ажилгүйдэл

Жилийн эцсийн байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 2607 хүн бүртгэлтэй байгаагийн 54.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйдчүүдийн тоо өнгөрсөн оноос 54.5 хувиар буюу 920 хүнээр нэмэгджээ.

Нийт бүртгэлтэй ажилгүйдчүүдийн 15.3 хувь нь 45-60 насныхан, 20.1 хувь нь 35-44 насныхан, 21.3 хувь нь 16-24 насныхан, 43.4 хувь нь 25-34 насныхан байна. Жилийн туршид бүртгэгдсэн ажилгүйдчүүдийн 32.9 хувь нь сургууль төгсөгчид, 11.6 хувь нь өөр газраас шилжин ирэгсэд байна. Ажилгүйдчүүдийн 43.1 хувийг бүрэн дунд, 36.0 хувийг дээд, 9.4 хувийг мэргэжлийн анхан шатны, 6.1 хувийг тусгай дунд, 4.3 хувийг суурь, 0.7 хувийг бага боловсролтой, 0.5 хувийг боловсролгүй хүмүүс эзэлж байна.

Тайлант онд нийт 4021 ажлын байр бий болсны 2018 буюу 50.2 хувь нь шинээр бий болжээ. Сүүлийн 4 жилд 6728 түр болон байнгын ажлын байр шинээр бий болсон байна.

Ажлын байраар хангагдагсдын 808 буюу 20.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 550 буюу 13.7 хувь нь худалдааны салбарт ажиллаж байна. Шинээр бий болсон ажлын байрны 25.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 23.0 хувь нь худалдаа, 11.6 хувь нь барилгын салбарт бий болжээ.

Гадаад худалдаа

Аймгийн хэмжээнд гадаад худалдаагаар 1.6 их наяд төгрөг буюу 802.3 сая ам долларын бараа эргэлт хийсэн байна. Өнгөрсөн оноос нийт эргэлт 11.8 хувиар буурсанаас импорт 35.2 хувиар, экспорт 5.8 хувиар буурчээ.

Гадаад худалдаагаар гол нэрийн бүтээгдэхүүнээс 594.9 мян.тн зэсийн баяжмал, 12.4 мян.тн катодын зэс, 4.4 мян.тн молибдены баяжмал, 64.8 мян.м2 хивс зэрэг 1.3 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүн экспортлож, тээрмийн ган бөмбөлөг 4.3 мян.тн, дизелийн түлш 33.6 мян.тн, бензин 33.1 мян.тн зэрэг нийт дүнгээр 237.6 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн импортоор авсан байна.

Өнгөрсөн оноос экспортолсон катодын зэс 96.8 хувиар, молибдений баяжмал 12.8 хувиар, зэсийн баяжмал 3.8 хувиар нэмэгдэж, хивс 22.3 хувиар багасчээ. Катодын зэсийн экспорт 96.8 хувиар өссөн нь “Ачит-Ихт” ХХК 2014 оны 9 сараас катодын зэс экспортолж эхэлсэнтэй холбоотой. Импортолсон тээрмийн ган бөмбөлөг 30.3 хувиар, бензин 20.4 хувиар их, дизелийн түлш 3.7 хувиар бага байна.



Үнэ

Хэрэглээний үнэ тарифын судалгааг хэрэглээний сагс дахь 213 нэр төрлийн бараа үйлчилгээнд хийв. Судалгааны дүнгээр үнийн ерөнхий индекс энэ сард 100.0 хувь болж өмнөх сарын түвшинд ба өмнөх оноос 0.6 хувиар өсч, 2010 оноос 1.6 дахин нэмэгджээ.

12-р сард гэр ахуйн барааны бүлгийн индекс 0.2 хувиар, хүнсний барааны бүлгийн индекс 0.4 хувиар өсч, бусад төрлийн бараа үйлчилгээний бүлгийн индекс 1.8 хувиар буурч, бусад бүлгүүдийн индекс өмнөх сарын түвшинд байна.

Хүнсний барааны бүлгийн индексийн өсөлтөд шингэн сүү 19.4 хувиар, хүнсний ногоо дунджаар 6.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



Банк, мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 1.5 их наяд төгрөгийг гүйлгээнээс татаж, 1.6 их наяд төгрөгийг гүйлгээнд гаргажээ. Өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээнээс татсан төгрөгийн хэмжээ 11.4 хувиар, гүйлгээнд гаргасан төгрөгийн хэмжээ 14.4 хувиар бага байна.

Иргэдийн хувийн мөнгөн хадгаламж 138.4 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дунджаар 1493011 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 1318438 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оны мөн үеэс хадгаламжийн үлдэгдэл 7.3 хувиар, хадгаламж эзэмшигчийн тоо 7.1 хувиар нэмэгджээ.

Арилжааны банкуудын дүнгээр 205.2 тэрбум төгрөгийн зээлийг 69.4 мянган иргэд, аж ахуйн нэгжид олгосноор зээлжигчийн тоо өнгөрсөн оноос 0.4 хувиар өсч, олгосон

зээлийн хэмжээ 18.1 хувиар багассан байна. Банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн сарын хүү 0.6 - 0.72 хувь, хугацаатай хадгаламжийн сарын хүү 0.7 - 1.65 хувь, харин хугацааны эцэст зарласан зээлийн сарын хүү 0.6 - 2.8 хувь байна.

Банк бус санхүүгийн 3 байгууллага, 11 хадгаламж зээлийн хоршоод 451 хадгаламж эзэмшигчийн 2.2 тэрбум төгрөгийн хадгаламжийг төвлөрүүлж, 2841 иргэд, аж ахуйн нэгжид 5.1 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Өнгөрсөн оны мөн үеэс зээлжигч 9.1 хувиар өсч, олгосон зээлийн хэмжээ 24.8 хувиар буурч хадгаламж 32.2 хувиар өсчээ.

2. Нийгмийн үзүүлэлт

Өрх, хүн ам

Аймгийн хэмжээнд 143 бүтэн өнчин, 978 хагас өнчин хүүхэд, 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 1573, өрх толгойлсон эмэгтэйчүүд 3032 байна. Өмнөх оноос хагас өнчин хүүхдийн тоо 7.5 хувиар нэмэгдэж бүтэн өнчин хүүхэд 7.7 хувиар буурчээ.



Хүн амын ердийн хөдөлгөөн

Тайлант онд төрсөн 2352 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 569 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 554 гэрлэлтийг бүртгэн, 191 гэрлэлтийг цуцалж, 57 хүүхэд үрчлэгдсэн байна. Өнгөрсөн оноос төрөлт 6.5 хувиар, нас баралт 9.0 хувиар, гэр бүл цуцлалт 15.1 хувиар, үрчлэлт 21.9 хувиар буурч, гэрлэлт 6.7 нэмэгджээ.

Бүртгүүлсэн гэр бүлийн 9.0 хувь тайлант онд гэр бүл болжээ. Гэрлэсэн эрэгтэйчүүдийн 43.1 хувь нь 25-29 насныхан, 25.5 хувь нь 20-24 насныхан, эмэгтэйчүүдийн 36.1 хувь нь 25-29 насныхан, 32.7 хувь нь 20-24 насныхан байна. Нийт гэр бүл цуцлалтын 25.8 хувь 7-9 жил гэр бүл байсан, үрчлэгдсэн хүүхдүүдийн 47.4 хувь нь 3 хүртэл насныхан байна.

Тайлант онд аймгийн дүнгээр 1000 хүнд ногдох төрөлт 25.4, нас баралт 6.1 промил болж, өмнөх оноос төрөлт 1.8 промилээр, нас баралт 0.6 промилээр буурчээ. 1000 өрхөд ногдох гэрлэлт 1.3 промилээр нэмэгдэж, цуцлалт 1.3 промилээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөн

УБХ-ийн мэдээгээр тайлант жилд 3263 хүн шилжин явж, 2374 хүн шилжин иржээ. Шилжин ирэгсдийн 37.8 хувь нь Улаанбаатар хотоос, 20.6 хувь нь Булган аймгаас, 6.7 хувь нь Хөвсгөл аймгаас шилжин ирсэн нь дийлэнх хувийг эзэлж байна. Насны хувьд шилжин ирэгсдийн 64.5 хувь нь 15-54 насныхан байна. Шилжин явагсдын 62.5 хувь нь Улаанбаатар хот руу шилжин явжээ. Шилжих хөдөлгөөн 1х1.4 харьцаатай байна.

Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 41.2 мянган хүнд 54.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 2.1 мянган хүнд 2.7 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, 2.1 мянган хүнд 1.1 тэрбум төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2.0 мянган хүнд 801.7 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 8.6 мянган ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 986.7 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 10.6 мянган хүнд 2.0 тэрбум төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт олгожээ. Өнгөрсөн оноос халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүн 2.8 хувиар олгосон халамжийн хэмжээ 11.2 хувиар өссөн байна.

Орон нутгийн бусад зардлаас 70-аас дээш насны 2.5 мянган ахмадад 25.4 сая төгрөгийн сар шинийн хүндэтгэл, 111 иргэнд 14.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж, Хөвсгөл аймаг дахь улсын асрамжинд 9 иргэн хүргэж өгөх зардалд 705,0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 59.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 93.8 хувийн биелж, ажилгүйдэлийг сангаас бусад сангуудын орлогын төлөвлөгөө 5.3 – 8.9 хувиар тасарчээ. Өнгөрсөн оноос сангуудын орлого дунджаар 5.2 хувиар нэмэгдсэн байна.

Шинээр 1448 хүнд тэтгэвэр тогтоосноос 68.7 хувьд нь өндөр насны, 24.2 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 7.0 хувьд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоожээ. Тэтгэвэр тогтоолгосон хүний тоо өмнөх оноос 24.6 хувиар буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалд даатгуулагсдын 66.0 хувь нь төр төлбөрийг нь даадаг, бусад нь заавал даатгуулагсад байна. Тэтгэврийн нэрийн данс нээлгэсэн хүний тоо, төлбөрийн нь төр хариуцдаг даатгуулагсдын тоо өмнөх оны түвшинд, заавал даатгуулагсдын тоо өмнөх оноос 1,5 хувиар өссөн байна.

Боловсрол

Боловсролын газрын мэдээгээр 2015-2016 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургуулийн 657 бүлэгт (үүнээс 4 нь цогцолбор сургууль) 18.1 мянган хүүхэд суралцаж, сургуулийн өмнөх боловсролын 39 байгууллагын 250 бүлэгт 7.5 мянган хүүхэд хамрагдаж, эдгээрт 1333 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна. Өнгөрсөн хичээлийн жилээс багш сурган хүмүүжүүлэгч 7.4 хувиар, суралцагсад 6.3 хувиар, СӨБ-д хамрагдаж байгаа хүүхэд 6.3 хувиар нэмэгдэж, хамралтын хувь 4.6 пунктээр буурчээ.

Нийт багш нарын 76.4 хувь нь ерөнхий боловсролын дунд сургуульд, 23.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох суралцагчийн тоо өмнөх оны түвшинд, нэг сургуульд ногдох

суралцагчид, багшийн тоо 3.4-3.5 хувиар, анги дүүргэлт 5.7 хувиар буурч, нэг цэцэрлэгт ногдох хүүхдийн тоо, цэцэрлэгийн нэг бүлэгт ногдох хүүхэд 0.8-4.2 хувиар нэмэгджээ.

2014-2015 оны хичээлийн жилд 2.2 мянган хүүхэд 9, 11-р ангийг төгссөнөөс 75.2 хувь нь суурь боловсролыг, 24.8 хувь нь бүрэн дунд боловсролыг эзэмшсэн байна. I-р ангид элсэгч 3.6 хувиар нэмэгдэж, X-р ангид элсэн суралцагч 8.4 хувиар буурчээ.

3 их, дээд сургуульд 1.9 мянган оюутан суралцаж байгаагийн 82.0 хувь нь их сургуульд сурч байна. Эдгээр их дээд сургуульд 132 орон тооны багш сургалт явуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын стандарт хангалт 98.9, чанар 74.9 хувь байна. Өмнөх хичээлийн жилээс стандарт хангалт 0.5 пунктээр буурч, чанар 0.6 пунктээр өсчээ. Сумдын ЗДТГ-ын мэдээгээр сургууль завсардсан 24 хүүхэд байгаагийн ихэнх нь Говил, Цагаанчулуут, Их залуу багуудад байна.



Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 71 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 11 нь өрхийн эмнэлэг, 55 нь хувийн эмнэлэг байна. Эдгээрт 266 их эмч, 615 дунд мэргэжилтэн ажиллаж байна. Хувийн хэвшлийн 11 эмнэлэг 149 ортойгоор ажиллаж байгаа нь нийт орны 24.9 хувийг эзэлж байна.

Аймгийн 10000 хүнд 29 их эмч, 66 дунд мэргэжилтэн, 65 ор, нэг их эмчид 349 хүн ногдож байна. Өмнөх оноос 10000 хүнд ногдох их эмч 0.3 продицимилээр өсч, дунд мэргэжилтэн 0.4 продицимилээр, нэг их эмчид ногдох хүн 3-аар багасчээ.

Эрүүл мэндийн байгууллагууд 560.7 мянган хүнд үзлэг хийснээс 36.9 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өнгөрсөн оноос нийт үзлэг 7.1 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 4.9 хувиар буурчээ.

Сэргийлэх тарилгад 17.2 мянган хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүний 97.5 хувь нь бөгөөд өнгөрсөн оноос хамралт 1.5 пунктээр буурсан байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 85.5 мянган хүнд үйлчилсэнээр, өмнөх оноос үйлчлүүлсэн хүний тоо 7.5 хувиар багасч, орлого 16.7 хувиар нэмэгджээ.

Жилийн дүнгээр 1 хүн дунджаар 6 удаа эмнэлэгт үзүүлсэн ба дунджаар 8 хоног эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2680 эх амаржин, 531 хүн нас баржээ. Нас баралтын 6.2 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. 1000 хүнд ногдох

төрөлт 2.0 промилээр, нас баралт 0.4 промилээр, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2.2 промилээр буурчээ. Тайлант хугацаанд эхийн эндэгдэл гараагүй байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн 1097 тохиолдол гарсан нь өнгөрсөн оноос 45.9 хувиар буюу 35.8 продицимилээр нэмэгдсэн байна. Нийт өвчлөлтийн 24.6 хувийг улаан бурхан, 21.3 хувийг тэмбүү, 10.8 хувийг мөөгөнцөр, 11.0 хувийг сүрьеэ, 7.2 хувийг трихоманаз, 7.1 хувийг хоолны хордлого, 6.3 хувийг салхинцэцэг, 3.4 хувийг суулгалт халдвар, 2.6 хувийг халдварт шар эзэлж байна. Нийт өвчлөлийн 30.5 хувь нь бэлгийн замын халдварт өвчин, үүний 69.8 хувь нь тэмбүүгээр, 23.6 хувь нь трихоманазаар, 6.6 хувь нь заг хүйтнээр өвчлөгсөд байна.

Өнгөрсөн оноос 10000 хүнд ногдох ёлом 0.1, сальмонеллэз 0.2, трихоманаз 0.2, эмнэлгийн дотоод халдвар 0.2, тэмбүү 0.8, сүрьеэ 2.5, салхинцэцэг 3.1, хоолны хордлого 7.2 продицимилээр нэмэгдэж, бусад халдварт өвчний гаралт 0.1-2.2 продицимилээр буурсанаас халдварт шар 2.2 продицимилээр буурчээ.

Урд онд гарч байгаагүй бүсэлхийн үлдээр өвчилсөн 1, херпес вируст цэврүүт дертатитаар өвчилсөн 2, улаан эсэргэнээр өвчилсөн 4, улаан бурханаар өвчилсөн 270 тохиолдол гарсан бол харин өмнөх онд гарч байсан хамуу, гахай хавдраар өвчилсөн тохиолдол гараагүй байна.

Соёл урлаг, биеийн тамир

Номын төв 31.5 мянган ширхэг сан хөмрөгийн номтой ба 7.8 мянган хүнд уншигчийн карт нээн өгч, 63.8 мянган хүнд 142.8 мянган ширхэг ном, хэвлэл олгон үйлчилжээ. Карттай уншигчийн 74.8 хувь нь, үйлчлүүлэгсдийн 68.8 хувь нь сургуулийн сурагчид байна. 0.9 сая төгрөгийн ном, соёлын бараа худалдаалжээ.

Соёл урлагийн байгууллагууд 267 удаа тоглолт хийн, 56.8 мянган хүнд тоглолт, үзмэрээ толилуулан, 757 удаагийн ажил зохион байгуулан 149.0 мянган хүнийг хамруулж, 3168 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оноос тоглолт 0.4 хувиар буурч, үзэгчдийн тоо 7.8 хувиар өсч, зохиогдсон ажил 4.3 хувиар буурч, хамрагдсан хүний тоо 59.3 хувиар нэмэгдсэн байна.

Манай аймгийн баг, тамирчид спортын уралдаан, тэмцээнээс 474 медаль хүртсэний 33.5 хувь нь алт, 31.0 хувь нь мөнгө, 35.5 хувь нь хүрэл медаль байна. Үүнээс дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 6 алт, 2 мөнгө, 10 хүрэл; ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 алт, 5 мөнгө, 11 хүрэл; олон улсын тэмцээнээс 4 алт, 9 мөнгө, 19 хүрэл медаль хүртжээ.

Спортын болон биеийн тамирын чийрэгжүүлэлтийн 37 төрлийн секцэнд 22.8 мянган хүн хичээллэсний 46.0 хувь нь насанд хүрэгчид, 54.0 хувь нь өсвөр үеийнхэн байна.



Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 565 хэрэгт 558 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 70.2 хувьтай байна. Өмнөх оноос бүртгэгдсэн хэрэг 0.7 хувиар, холбогдогч 7.2 хувиар, 18–аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 0.6 процицимилээр буурч, хэргийн илрүүлэлт 0.2 пунктээр нэмэгджээ.

Нийт бүртгэгдсэн хэргийн 40.0 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 30.3 хувь нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг, 7.8 хувь нь хүнд, онц хүнд хэрэг байгаа ба өнгөрсөн оноос согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 7.6 хувиар нэмэгдэж, хүнд, онц хүнд хэрэг 22.8 хувиар, бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 10.9 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл нийт хэргийн 40.5 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, 24.2 хувийг хулгайн хэрэг, 10.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг, 9.6 хувийг залилан мэхлэх, завшиж үрэгдүүлэх хэрэг, 2.5 хувийг хүчингийн хэрэг, 1.9 хувийг танхай, 1.8 хувийг орчиндоо аюул учруулах амьтныг хамгаалалтгүй байлгах хэрэг, 0.9 хувийг булаах хэрэг, 0.9 хувийг дээрмийн хэрэг, 0.7 хувийг хүн амины хэрэг, 0.5 хувийг албан тушаалын хэрэг эзэлж байна.

Өнгөрсөн оноос хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, хулгайлах, танхайрах, булаах, хүнийг санаатай алах, дээрэмдэх хэргийн гаралт 3.3-66.7 хувиар багасч, бусад хэргийн гаралт 1.3%-3.0 дахин нэмэгдсэний дотор албан тушаалын хэрэг 3.0 дахин буюу 2-оор нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1.7 тэрбум төгрөгийн хохирол учирч, 22 хүн нас барж, 310 хүн хүнд ба хөнгөнөөр гэмтжээ. Нийт хохирлын 65.8 хувийг нь нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт холбогдсон 558 хүний 55.0 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 41.9 хувь нь согтуугаар, 19.5 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн ба 5.6 хувь нь 18 хүртэл насны хүүхэд байна.

29 холбогдогчтой, 38.7 сая төгрөгийн хохирлын хэмжээтэй хүүхдийн 27 гэмт хэрэг гарч, өнгөрсөн оноос гэмт хэргийн тоо 25.0 хувиар, холбогдогч 38.3 хувиар, учруулсан хохирлын хэмжээ 40.5 хувиар буурчээ.

Хэв журмын нөхцөл байдлын хувьд 5.0 мянган хүн эрүүлжигдэн, 797 хүн захиргааны шийтгэлээр баривчлагдаж, хутга мэстэй холбоотой 92 зөрчил гарч, өнгөрсөн оноос баривчлагдсан хүний тоо 15.5 хувиар, хутга мэстэй холбоотой зөрчил 0.6 хувиар буурч, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 0.3 хувиар нэмэгджээ.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 2155 жолоочийг илрүүлэн, 1608 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өмнөх оноос согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 0.8 хувиар буурч, эрх хасалт 0.2 хувиар нэмэгдсэн байна.

Шүүхээр 1719 хэрэг шийдвэрлэсний 1.7 хувийг захиргааны, 13.9 хувийг эрүүгийн, 84.4 хувийг иргэний хэрэг эзэлж байгаа ба өнгөрсөн оноос нийт шийдвэрлэсэн хэрэг 23.4 хувиар, иргэний хэрэг 27.8 хувиар, эрүүгийн хэрэг 12.7 хувиар нэмэгдэж, захиргааны хэрэг 37.0 хувиар буурчээ.

Аймгийн хэмжээнд 181 гал түймэр, галын зөрчил гарснаас ил задгай гал, асгасан үнс нурамнаас 59, цахилгаан угсралт, ашиглалтын буруугаас 33, пийшин, зуух, яндангийн цоонолтоос 26, лаа, дэн, тамхи, шүдэнзний галаас 13 гал түймэр, галын зөрчил гарчээ. Эдгээрээс 240.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оноос 29.5 хувиар их байна.

3.Үйлдвэрлэл үйлчилгээний талаар.



Аж үйлдвэрийн салбарт 1.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 1.3 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өнгөрсөн оноос үйлдвэрлэлт 11.3 хувиар, борлуулалт 10.4 хувиар буурчээ. Нийт бүтээгдэхүүний 99.9 хувь нь Баян-Өндөр суманд, 0.1 хувь Жаргалант суманд үйлдвэрлэгджээ.

Өнгөрсөн оноос үйлдвэрлэлт боловсруулах аж үйлдвэрийн салбарт 29.6 хувиар, цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 17.7%-иар өсч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 11.3 %-иар буурчээ.

Нийт бүтээгдэхүүний 88.3 хувийг уул уурхайн олборлох, 9.4 хувийг боловсруулах, 2.3 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 57.8 хувийг төмрийн үйлдвэрлэл, 16.2 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 13.8 хувийг ноосон нэхмэлийн үйлдвэрлэл, 5.9 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 2.6 хувийг оёдол, 2.2 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, 0.6 хувийг резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэвлэх үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эд бэлтгэл, тавилга үйлдвэрлэл тус бүр 0.2 хувийг эзэлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийн 78.3 хувь нь гурил, тэжээлийн үйлдвэрлэлт, 11.6 хувь нь хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 5.5 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 4.2 хувь нь мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.4 хувь нь архи, ундаа үйлдвэрлэлт байна.

Эрдэнэт фүүдс ХХК мэдээнд хамрагдсанаар гурил, тэжээлийн үйлдвэрлэлт, “Ганчагт” ХХК, “Ачит-Эхт” ХХК-г мэдээнд нэмж хамруулсанаар төмрийн үйлдвэрлэлт, “ББСН” ХХК, “Орхон хийц” ХХК мэдээнд нэмж хамруулсан болон “РСЦ” ХХК бетон зуурмаг

өмнөх оноос их хэмжээгээр үйлдвэрлэснээр төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэлт, “Ойном” ХХК бүтээгдэхүүний сав баглаа боодлоо шинэчилж, үнээ нэмсэнээр химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өссөн байна.

Гол нэр төрлийн 65 бүтээгдэхүүнийг судалгаанд хамруулснаас тараг, хулдаасан хэвлэл, ажлын хувцас, зэсийн баяжмал, бялуу, хайрга, эсгий, 1-р гурил, молибдений баяжмал, металл хийц, ном, хаалга цонх, хивэг, боловсруулсан сүү, 2-р гурил, 3.0-69.8 хувиар, ноосон алчуур, хэвийн боов, монгол эм, банш бууз, эсгий шаахай, уртасгагч залгуур, дарс, катодын зэс 3.0-7.0 дахин өсч, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 0.1-99.5%-иар буурсны дотор ямааны мах бэлтгэл 99.8%-иар буурчээ. 2014 онд үйлдвэрлэгдэж байсан амтат ундаа, улаан тоосго энэ онд үйлдвэрлэгдээгүй байна.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 3.2 хувиар өсч, хөдөлмөрийн бүтээмж 9.7 хувиар буурчээ. Төмрийн үйлдвэрлэлийн салбарын хөдөлмөрийн бүтээмж өмнөх оноос 71.2 хувиар өссөн нь “Ачит-Ихт” ХХК катодын зэсний үйлдвэрийг мэдээнд нэмж хамруулсантай холбоотой.



Хөдөө аж ахуй

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогод 765 малчин өрхөд 119.8 мянган мал тоологдов. Өмнөх жилийнхээс малын тоо 2.8 хувиар, малчин өрх 16.8 хувиар, малтай өрх 18.2 хувиар буурсан байна. Тэмээ, хонь, ямааны тоо буурч, үхэр сүрэг өсчээ.

Нийт малчдын 62.9 хувь нь 35-60 насны, 19.6 хувь нь 16-34 насны, 17.5 хувь нь тэтгэвэрийн насны малчид ба эдгээрийн 46.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Бэлэн малын 96.0 хувь нь иргэдийн хувийн, бусад нь албан газрын мал бөгөөд нийт малын 40.2 хувийг хонь, 36.2 хувийг ямаа, 16.0 хувийг адуу, 7.6 хувийг үхэр, эзэлж, нийт малын 23.7 хувь нь бод мал байна.

Аймгийн 12 аж ахуйн нэгж байгууллагад 4874 толгой мал тоологджээ

Өнгөрсөн оноос Баян-Өндөр сумын мал 7.9 хувиар өсч, Жаргалант сумынх 8.1 хувиар буурсан ба нийт малын 63.0 хувь нь Жаргалант суманд байна.

Нийт малтай өрхийн 24.1 хувь нь 100 хүртэл толгой малтай ба мянгат малчин 2 өрх байна. Аймгийн дүнгээр малтай нэг өрхөд 106, малчин нэг өрхөд 150.1 толгой мал ногдож, өмнөх оноос малчин нэг өрхөд ноогдох малын тоо 14 толгойгоор багассан байна.

55.4 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 46.2 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 1.0 хувь буюу 500 гаруй толгойгоор өсчээ. 1091 хээлтүүлэгч малын 48.0 хувь нь хуц, ухна байна. Нэг хээлтүүлэгчид 7 ингэ, 9 гүү, 37 үнээ, 82 эм хонь, 88 эм ямаа ногдож байна. Ингэ, гүү үржлийн нормт хэмжээнээс доогуур, эм хонь, эм ямаа ихээхэн дээгүүр, үүнээс бог малд норм 2.7-2.9 дахин их бөгөөд хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо алдагдсан байна.

Оны эхний төллөх эх малын 88.8 хувь буюу 48.7 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төлийн 98.3 хувь нь бойжиж байна. Өмнөх оноос төллөлт 18.4 пунктээр их, төл бойжилт 0.5 пунктээр бага байна. Нийт гарсан төлийн 1.7 хувь буюу 825 төл хорогджээ. 100 эхээс бойжуулсан төлийн тоо бүх төрөл дээр өссөн байна.

827 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 99.3 хувьтай байна. Нийт хорогдсон малын 31.2 хувь нь хонь, 34.7 хувь нь ямаа, 25.2 хувь нь үхэр, 8.9 хувь нь адуу байна.

Баян-Өндөр сумын төллөх эх малын 84.9 хувь, Жаргалант сумын төллөх эх малын 90.7 хувь нь төллөж, гарсан төлийн 97.2-98.8 хувь нь бойжиж байна.

Жаргалант суманд 493 толгой том мал зүй бусаар хорогдсон нь аймгийн нийт хорогдлын 59.6 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 576 гахай, 2285 шувуу, 126 туулай, 5 цаа буга, 301 бүл зөгий тоологдож, өмнөх оноос гахай 13.6 хувиар буурч, шувуу 1.9 дахин, зөгий 3.3 дахин, туулай 3.1 дахин өссөн байна.

Аймгийн мал эмнэлэгийн байгууллагууд давхардсан тоогоор 250.4 мянган мал, амьтдыг үзлэгт, 174.6 мянган мал амьтдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 346.8 мянган толгой мал амьтдыг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулжээ. Өмнөх оноос үзлэг хийсэн мал амьтад 11.0 хувиар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан мал амьтад 1.8 хувиар өсч, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал амьтад 18.8 хувиар буурчээ.

Паразит өвчнөөр 33.4 мянган мал, амьтан өвчилснөөс 15 нь, халдварт өвчнөөр 44 толгой мал, амьтан өвчилснөөс 39 нь хорогдсон байна.

Аймгийн хэмжээнд 239 худаг, 279.8 мян.м.куб багтаамж бүхий 45 усан сан тоологдсоноос 105 худаг нь хувийн аж ахуйнх байна. Тайлант онд 3 худгийг сэргээн засварласан ба нийт худаг усан сангийн 262 нь ашиглагдаж байна.

Хаврын тариалалтаар 4014.5 га-д үр тариа (үүнээс 3998.0 га-д улаан буудай, 6.0 га-д овьёос, 0.5 га-д хөх тариа, 10.0 га-д арвай), 255.9 га-д төмс, 261.0 га-д хүнсний ногоо тариалсанаас үр тарианы төлөвлөгөөт зорилт 125.5 хувь, төмс 74.5 хувь, хүнсний ногоо 91.6 хувь, малын тэжээл 58.0 хувьтай байна. Үр тарианы 54.2 хувь, төмсний 17.2 хувь, хүнсний ногооны 13.6 хувийг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалжээ.

Намрын ургац хураалтаар 3481.5 га-гаас 4950.4 тн үр тариа, 249.9 га-аас 2513.6 тн төмс, 243.2 га-аас 2745.1 тн хүнсний ногоо хураан авчээ. Тариалсан талбайн 1 га-аас 14.2 цн үр тариа, 100.6 цн төмс, 113.0 цн хүнсний ногоо хураасан нь өмнөх оноос төмс 4.4 цн-ээр өсч, үр тариа 19 цн, хүнсний ногоо 47.3 цн-ээр багасчээ.

Нийт үр тарианы 43.6 хувь буюу 2160.4 тн, төмсний 18.7 хувь буюу 469.3 тн, хүнсний ногооны 7.7 хувь буюу 210.5 тн ургацыг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалж, хураасан байна.

Жилийн дүнгээр 7.8 мянган тн хадлан бэлтгэхээс 7.6 мянган тн-ыг бэлтгэж, төлөвлөгөөт зорилт 97.9 хувиар биелэжээ. Үүнээс Баян-өндөр сум 3.2 мянган тн, Жаргалант сум 4.4 мянган тн-ыг, аймгийн нөөцөнд Баян-Өндөр сум 100.0 тн-ыг, Жаргалант сум 156.0 тн-ыг бэлтгэж нийт 256 тн хадланг нөөцлөв.

Байгаль орчин, цаг уур

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур 11.4 хэмийн хүйтэн байж, өнгөрсөн оны мөн үеэс 3.2 хэмээр дулаан, хур тунадас 0.1 мм-ээр их байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэдээгээр тайлант хугацаанд 20.0 га талбайг ойжуулж, 60.0 мянган ширхэг шилмүүст мод, 2.0 мянган ширхэг навчист мод, 85.9 мянган ширхэг тарьцыг хүлэмж болон ил талбайд тариалжээ. Өмнөх оноос ил талбайд болон хүлэмжинд тарьсан тарьцын тоо 5 дахин багассан байна. Энэ нь цаг агаарын байдлаас шалтгаалжээ.



Барилга

Их барилгын 74 аж ахуйн нэгж 73.5 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 137 объектод хийж гүйцэтгэсэний 24.3 хувь буюу 17.9 тэрбум төгрөг нь их засварын ажил байна. Гүйцэтгэсэн ажлын дүн өнгөрсөн оноос 4.5 хувиар багасчээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөрт 108 объектод 19.4 тэрбум төгрөгийн, Улсын төсвийн хөрөнгөөр 7 объектод 1.7 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оноос 10.6-69.1 хувиар бага байна.

Тайлант онд аймгийн дүнгээр 9.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 объектийг ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 2.9 дахин бага байна.



Тээвэр

Тээврийн байгууллагууд 142.5 мян/тн ачаа тээвэрлэн, 51.4 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 5.6 сая зорчигч тээвэрлэн, 95.9 сая хүн/км-ийн зорчигч эргэлт хийж, тээврийн үйлчилгээнээс 11.9 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ.

Өнгөрсөн оноос ачаа эргэлт 16.1 хувиар өсч, зорчигч эргэлт 24.4 хувиар, орлого 23.8 хувиар буурчээ. “Тээвэр авто замын газар” хувиараа ачаа тээвэр эрхэлдэг 77 иргэний ачаа эргэлтийг мэдээнд хамруулсанаар ачаа эргэлт нэмэгдсэн байна. Зорчигч тээврийн үйлчилгээнд 501 такси, 86 микроавтобус, 41 автобус гарч тэдгээрт 843 хүн ажиллаж байна. “ББ-Од” ХХК нь дунд оврын 12 автобусыг үйлчилгээнд оруулж ажиллуулснаар микроавтобус, такси болон ажиллагсдын тоо буурсан байна.

Жилийн туршид авто техникийн улсын үзлэгт 14.4 мянган автомашин хамрагдсанаас 78.5 хувь нь суудлын машин, 17.3 хувь нь ачааны машин, нийт авто техникийн 86.1 хувь нь иргэдийн хувийн автомашин байна. Үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо өмнөх оноос 16.4 хувиар нэмэгджээ.

Төмөр замын тээврээр 502.5 мянган тн ачаа тээвэрлэн, 356.2 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 137.8 мянган зорчигч тээвэрлэн, 29.0 сая хүн.км-ийн зорчигч эргэлтийг хийж, 7.6 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оны мөн үеэс тээвэрлэн импортолсон барилгын материал 21.3 хувиар, элсэн чихэр 18.2 хувиар, цагаан будаа 10.9 ургамалын тос 8.4 хувиар, гурил 5.2 хувиар буурсан байна.

Мэдээлэл харилцаа холбоо

Холбооны байгууллагууд 8.1 тэрбум төгрөгийн тарифын орлоготой ажилласны 89.4 хувь нь хүн амын үйлчилгээний орлого байна. Өнгөрсөн оноос кабелийн телевизийн орлого 13.9 хувиар, мэдээлэл холбооны орлого 7.3 хувиар нэмэгдэж, бусад үйлчилгээний орлого 20.0-35.3 хувиар буурчээ.

Нийт орлого өмнөх оноос 27.5 хувиар буурсаны дотор үүрэн телефоны орлого 35.3 хувиар буурсан байна.

Интернет байнгын хэрэглэгчийн тоо 2.4 дахин нэмэгдсэн нь юнивишн цэгийн үйлчилгээг мэдээнд хамруулсантай холбоотой. Интернетийн үйлчилгээний 8 цэг давхардсан тоогоор 46.8 мянган хүнд үйлчилгээ үзүүлжээ.



Худалдаа

Аймгийн худалдаа нийтийн хоолны 664 цэг салбар 87.7 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өнгөрсөн оноос 19.8 хувиар буурчээ.

Нийт бараа гүйлгээний 35.5 хувийг хүнсний дэлгүүр, 36.2 хувийг шатахуун борлуулалт, 12.6 хувийг зоогийн газар 10.1 хувийг барааны дэлгүүр, 2.9 хувийг эм борлуулалт, 1.3 хувийг контейнер 1.0 хувийг барилгын материал, 0.2 хувийг авто засвар, 0.1 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого эзэлж байна.

Өмнөх оноос контейнерын орлого эм борлуулалт 22.3 хувиар, 0.3 хувиар өсч, барааны дэлгүүр, ТҮЦ, шатахуун, зоогийн газар, хүнсний дэлгүүр, барилгын материалын дэлгүүр, авто засварын газар, авто сэлбэгийн дэлгүүрийн орлого 1.9 -80.9 хувиар буурчээ. “Мишээл” эмнэлгийн эмийн худалдааны орлого, “Бамбай” эмийн сан мэдээнд хамрагдсан нь эмийн борлуулалтын орлогын өсөлтөнд нөлөөлжээ.

Нийт бараа гүйлгээний 99.5 хувь нь Баян-Өндөр суманд хийгдсэн байна.

Нийтийн аж ахуйн болон ахуйн үйлчилгээ

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого 14.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 14.6 хувиар өссөн байна. Нийт орлогын 41.3 хувийг орон сууц, 40.9 хувийг аж ахуйн нэгж, 10.6

хувийг зочид буудал, 3.2 хувийг хог тээвэрлэлт, 2.0 хувийг засвар үйлчилгээ, 1.2 хувийг зөөврийн цэвэр ус борлуулалт, 0.4 хувийг халуун ус, 0.3 хувийг сауны орлого бүрдүүлжээ.

Өнгөрсөн оноос иргэдийн үйлчилгээ, зочид буудал, засвар үйлчилгээ, сауны орлого 5.7-58.6 хувиар буурч, бусад үйлчилгээний орлого 10.4-29.1 хувиар нэмэгджээ. Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлогын 99.7 хувийг Баян-Өндөр сум эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний салбарт 1.7 тэрбум төгрөгийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн нь өмнөх оноос 6.3 хувиар бага байна. Нийт орлогын 49.2 хувийг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, 27.7 хувийг үсчин, 11.9 хувийг прокат ба тоглоомын цэг, 4.1 хувийг гэрэл зураг, 3.1 хувийг хими цэвэрлэгээ, 3.3 хувийг гутал засвар, 0.5 хувийг телевизор засвар, 0.2 хувийг цаг засварын орлого эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний орлогын 99.9 хувийг Баян-Өндөр сум бүрдүүлжээ. Жаргалант суманд зөвхөн 2 үсчин үйл ажиллагаа явуулж байна.

Сууц өмчлөгчдийн 4 холбоо шинээр байгуулагдсанаар холбооны тоо 28 болж, 1.1 тэрбум төгрөгийн орлого, 1.0 тэрбум төгрөгийн зарлагатай ажиллан өмнөх оноос орлого, зарлага 52.0-36.4 дахин өсчээ. Барилгын засвар үйлчилгээний зардалд 297.4 сая төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оноос 39.6 хувиар өссөн байна. Нийт зардлын 29.3 хувийг барилгын засвар үйлчилгээнд зарцуулсан нь өмнөх оны түвшинд байна.

Бүртгэл, хяналт шалгалт

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр энэ онд 297 аж ахуйн нэгж, байгууллага нэмэгдэн, 57 аж ахуйн нэгж хасагдсанаар (татан буугдсан, шилжсэн) аж ахуйн нэгж, байгууллагын тоо 4038 болж, оны эхнийхээс 6.3 хувиар нэмэгджээ.

Тайлант онд аж үйлдвэрийн салбарт “Ачит-Ихт” катодын зэс үйлдвэрлэл, “ББСН” төмөр хийц үйлдвэрлэл, “Хээтэй шил” шилэн хийц үйлдвэрлэл, “Зөв эхлэл стандарт мёд” хэвлэх үйлдвэрлэл, “Орхон түнш” металл хийц үйлдвэрлэл, “Анд-Энерги” лед гэрэл үйлдвэрлэл, “Конкрете бетон хийц” бетон зуурмаг үйлдвэрлэл, “Өлзий хутгийн зам” аспалтан зуурмаг үйлдвэрлэл, “Аархал тайж” гутал үйлдвэрлэл, “Тибижи” тавилга үйлдвэрлэл, “Мёосотс” мөс үйлдвэрлэл, “Ойгон хатан ээж” хэрчсэн гурил үйлдвэрлэл, “Смүксолошн” хэвлэх үйлдвэрлэл, “Нарантунамал” барилгын материал үйлдвэрлэл, “Их тод од” ариун цэврийн цаас үйлдвэрлэл, оёдлын 2 /Хишигсүрэн, Түмэн-Өлзий/ иргэн, Эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүдийн Ladies Life, Хатагтай, нүдний Шинэ эрин, уламжлалт бариа заслын Тэгш нуруу, хүүхдийн Оюу чагнуур эмнэлэг, Боловсролын салбарт тайлант хичээлийн жилд шинээр нээгдсэн төсвийн Бүжинхэн, Унага, хувийн хэвшлийн Энхжин цэцэрлэгийг, Барилгын салбарт “Хуйвт уул констракшн” ХХК “Жавхлант харгуй” ХХК болон, барьцаалдан зээлдүүлэх үйлчилгээний 25 компани бүгд 52 нэгжийг статистикт шинээр хамрууллаа.

Аймгийн дүнгээр 826 иргэнд 59.75 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, 60 аж ахуйн нэгжид 477.68 га газрыг аж ахуйн бусад зориулалтаар эзэмшүүлэхээр, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийн дагуу хүсэлт гаргасан 925 өрхөд 65.37 га газрыг хувьчилж олгожээ. Газар олголт өссөн нь 2013, 2014 онуудад олгосон газрыг 2 жил ашиглаагүйгээс хурааж дахин олгосонтой холбоотой байна.

Энэ оны газрын төлбөрийг бүрэн төвлөрүүлж, өмнөх жилийн дутуу төлөлт 1.6 тэрбум төгрөгийг нэмж төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн Өмчийн албанаас 2 удаа дуудлага худалдаа зохион байгуулж, 13.5 сая төгрөгийн анхны үнэ бүхий 7 суудлын машиныг 14.2 сая төгрөгөөр худалджээ.

Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл баталгаажуулалтаар 1310 орон сууц, 9027 гэрээ, 990 газар өмчлөх эрхийг бүртгэн баталгаажуулж, 111.9 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өнгөрсөн оноос 30.8 хувиар бага байна.

Стандартчилал хэмжил зүйн төв 9.7 мянган хэмжүүр, хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийсэн нь өнгөрсөн оноос 20.9 хувиар бага байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС